

ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ МЭДЭЭ

Гадаад зах зээл

2023.11.17



ОНЦЛОХ МЭДЭЭ :

Зөв тэнцвэрт оруулах нь

Өнгөрсөн 7 хоногийн мэдээнээс онцлох зүйлс:

Онцлох мэдээ:


- Сүүлд гарч буй эдийн засгийн мэдээнүүд хөрөнгийн зах зээлд 10 сараас хойш нэлээдгүй өсөхөд нөлөөлж голдиролд (хэт өөдрөг эсвэл гутранги биш) нь оруулав.
- Инфляц буурсаар байна, ялангуяа суурь инфляц сүүлийн 2 жилийн доод түвшинд хүрлээ. Хажуугаар нь хөдөлмөрийн зах зээл саарч байгаа нь ХНС-г мөнгөний бодлогоо ирэх 2-р хагас жилээс зөөлрүүлэхэд хүргэж магадгүй байна.
- Шинжээчид ЗГҮЦ-ны өгөөж буурснаар хувьцаа болон бондын зах зээлд боломжууд гарч ирэх талаар онцолж байна. Эдийн засгийн өсөлт саарч болзошгүй ч 2024 онд суурь үзүүлэлтүүд харьцангуй эерэг байх хүлээлттэй байна.

Усанд орохын өмнө усны хэмээ тааруулахтай адил сүүлд гарч буй мэдээнүүд зах зээлийн тэнцвэрийг нь олсон байхгүй бол болдоггүй. Хэт халуун байвал эдийн засаг өсөж, инфляц хяналтаас гарч, ХНС-г бодлогын хүүг өсгөхөд хүргэнэ. Харин хэт хүйтэн байвал эдийн засаг хямралд орж, зах зээл уналтад орно. Энэ 11 сарыг хүртэл зах зээл дэх хэм харьцангуй тэнцвэрийг нь олсон байгаа тул хөрөнгийн зах зээлийг өсөхөд хүргэсэн. Энэхүү тааламжтай үе үүрд үргэлжлэхгүй ч 2024 онд суурь үзүүлэлт эерэг байх 3 үндэслэлийг дэлгэрүүлэн харцгаая.

1. Инфляц буурсаар

- Зун бага зэрэг өссөн боловч 10 сарын байдлаар инфляц тогтмол буурсаар байна. Нэрлэсэн инфляцын түвшин 3.7%-иас 3.2% болж буурсан нь шатахууны үнэ унасантай холбоотой байв. Газрын тосны ханш 9 сарын оргил цэгээсээ 20% унасан нь эрчим хүч, шатахууны үнийг буурахад нөлөөлжээ. Суурь инфляц 4.1%-иас 4.0% болсон нь зорилтот түвшнээс дээгүүр боловч сүүлийн 2 жилийн доод түвшинд хүрсэн юм.
- Цааш нь задалж үзэхэд илүү өөдрөг зүйлс ажиглагдсан юм. Жишээлбэл бараа, материалын үнэ сүүлийн 5 сар дараалан буурч, нийлүүлэлтийн гинжин хэлхээ сайжирсны улмаас тээвэрлэлтийн өртөг буурчээ. Одоогоор инфляцыг өндөр байхад нөлөөлж байгаа хамгийн том хүчин зүйл нь орон сууц, тэр дундаа түрээсийн үнэ байна. Гэвч 10 сарын мэдээнээс харахад, шинээр байгуулсан түрээсийн гэрээний дүн буурсан нь үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт 2024 онд илүү ажиглагдах болов уу.
- Шинжээчид инфляцыг ХНС-ийн таамаглаж буйгаас илүү хурдтай унана гэж харж байна. Иймд, эрх баригчид ирэх сарын уулзалтаар инфляцын төсөөллөө өмнөхөөсөө буулгаж магадгүй юм. Одоогоор ХНС-ийн инфляцын төсөөллөөр 2023 оны эцсийн байдлаар 3.7%, 2024 онд 2.6%-тай байна.


Инфляци буурах хандлагатай хэвээр байгаа нь ХНС-ийн үүрэх ачааг бууруулж байна



2. Эдийн засгийн өсөлт бага зэрэг саарч байгаа ч үйлдвэрлэл тэлсээр байна

- Энэ сарын худалдан авалт болон хөдөлмөрийн мэдээнээс харахад дунджаас илүү байсан өсөлт цаашид буурах хандлагатай байна. Энэхүү бууралт нь хэдийгээр удаан байгаа ч ХНС-ийн инфляцыг бууруулах ажилд чухал үүрэг гүйцэтгэх болно.
- Өнгөрсөн сард худалдан авалт таамаглаж байснаас багаар (-0.1% vs. -0.3%) буурсан боловч ДНБ-ий тооцоололд голлон нөлөөлдөг шатахуун, автомашин, барилгын материал, хүнсний үйлчилгээ зэрэг салбаруудад 0.2%-ийн өсөлт ажиглагджээ. Сайшаалтай нь өрхийн худалдан авалт өсөж байгаа нь эдийн засагт эергээр нөлөөлөх боловч цаашид саарах төлөвтэй байна.
- Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо 8 сараас хойш хамгийн ихээр өссөн ба цаашид ч өсөх хандлагатай байна. Хэдийгээр сүүлийн 2 жилийн дээд хэмжээнд хүрсэн байгаа ч сүүлийн 50 жилийн дунджаас 30% доогуур байна. Эрэлт буурч, компаниуд цомхотгол хийснээр шинээр зарлагдаж буй ажлын байрны тоо болон ажилгүйдлийн түвшин хоёрын тэнцвэр эргээд хэвэндээ орохоор байна.
- Projected long-term potential growth rate of U.S. economy: 1.8%


ДНБ-ий өсөлт 4-р улиралд удааширч магадгүй ч эдийн засгийн өсөлт хадгалагдсан хэвээр



3. ЗГҮЦ-ны өгөөж буурснаар ХНС-ийн мөнгөний бодлогод өөрчлөлт орох болно

- 11 сард хувьцаа болон бондын ханш хүчтэй өссөний шалтгаан нь инфляц буурсан, хөдөлмөрийн зах зээл саарсан, ХНС бодлогын хүүгээ өсгөхөө зогсооно гэсэн хүлээлттэй холбоотой байсан. Суурь инфляц сүүлийн 2 жилийн доод хэмжээнд хүрснээр шинжээчид 12 сарын бодлогын хүүгийн өсгөлтийг таамаглалаас хасаж, хүүгийн бууруулалтыг эрт эхэлнэ гэж харж байна. Бодлогын хүүнд эмзэг 2 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж 5.0%-иас доош орсон бол өсөлтөд мэдрэмтгий 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж 4.5%-иас доош орсон юм.
- Шинжээчид өнгөрсөн сарын өгөөжийн огцом өсөлтийг бодлогын хүүгийн түвшинд тааз тогтсоны илрэл байсан гэж үзэж байгаа ба сүүлд гарч буй мэдээнүүд сайн байгаа тул ирэх зунаас ХНС бодлогын хүүг бууруулж магадгүй гэсэн хүлээлттэй байна.


ХНС хүүгээ тийм амархан зөөлрүүлэхгүй ч 2024 онд хүүгээ 9 сард төсөөлж байснаас хоёр дахин их бууруулах магадлалтай.



2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

- Эдийн засгийн мэдээнүүд таатай байснаар хөрөнгийн зах зээлд энэ сард ихээхэн өсөлттэй байлаа. Өнгөрсөн 7 хоногийн хөдөлгөөнөөс нэг анхаарал татсан зүйл нь хөрөнгийн зах зээл ихэнх салбарт өсөлт ажиглагдсан нь байсан юм.
- Саяхныг хүртэл хөрөнгийн зах зээлд ердөө “Гайхамшигт 7” (Alphabet, Amazon, Apple, Meta Platforms, Microsoft, Nvidia, Tesla) хувьцаа л хамгийн их өссөн бол бусад хувьцаанууд уналттай байсан юм. Гэвч өнгөрсөн 7 хоногт бага зах зээлийн үнэлгээтэй компаниудын хувьцааны ханш өссөн нь 2024 онд өрнөж болзошгүй хөдөлгөөнийг хөрөнгө оруулагчдад цухуйлгасан байж магадгүй.
- Шинжээчид бодлогын хүү өндөр байсны улмаас уналттай байсан хувьцаанууд дээр боломж байгааг онцолж байна. Тэр дундаа хамгаалалтын салбарын, бага зах зээлийн үнэлгээтэй, хямд хувьцаануудыг сонирхож байна. Эдийн засгийн өсөлт алгуурхан буурвал ХНС ирэх жил бодлогын хүүг бууруулах илүү боломжтой болно. Энэ үед долларын ханш сулрах магадлалтай тул олон улсын хувьцаанууд ашигтай байх боломжтой. Өгөөж унаж байгаа нь бондын ханшийн өсөлт 2024 онд бэлэн мөнгөнөөс илүү ашигтай байлгахаар байна.
- Бидний өмнөх дугаарт дурдаж байсанчлан эдийн засгийн мэдээ, өсөлтийн тэнцвэр зөв тогтсоны үр дүнд жилийн эцсийн өсөлт болоход шаардлагатай нөхцөл бүрдлээ. Гэвч, хөрөнгийн зах зээл шулуун шугамаар хөдөлдөггүйг хөрөнгө оруулагчид санах хэрэгтэй ба өсөлтийн араас хэлбэлзэл угтахыг үгүйсгэж болохгүй юм. Бодлогын хүү буурч, компаниудын ашигт ажиллагаа өссөнөөр ирэх жилд хөрөнгийн зах зээл өсөх бүрэн боломжтой байна.

Зах зээлийн хоцрогдлоо 2024 онд нөхөх боломжтой



САНАМЖ

Энэхүү мэдээлэл нь Ард Секюритиз ҮЦК-иас зөвхөн мэдээллийн зорилгоор бэлтгэгдсэн болно. Илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн шинжээчийн байр суурийг илэрхийлэх бөгөөд зах зээл болон бусад хүчин зүйлсийн нөлөөллөөр өөрчлөгдөх боломжтой юм. Бүх мэдээ, мэдээллүүд нь үүнд Ард Секюритиз ҮЦК-ийн эх сурвалж болгосон буюу гаргасан мэдээлэл үнэн бодит гэж үзсэн эх сурвалжаас авсан боловч нарийвчлал нь баталгаажуулаагүй болно. Өнгөрсөн үзүүлэлт нь ирээдүйн үр дүнгийн баталгаа болохгүй. Тиймээс та өөрт нийцсэн хөрөнгө оруулалт эсвэл арилжаа хийхдээ бие даан буюу өөрийн зөвлөхтэйгөө зөвшилцөж шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг анхаарна уу!